

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 8 дугаар  
сарын 18-ны өдөр


Дугаар 250

Улаанбаатар  
хот

## Үндэсний хорооны бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1, 2.5.8 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Олимпизмыг дэлгэрүүлэх, хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтийг хангах, амьдралын чанарыг дээшлүүлэх үндэсний хорооны бүрэлдэхүүн”-ийг “Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүрэлдэхүүний тухай” Засгийн газрын 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоолын 34 дүгээр хавсралт болгон хавсралт ёсоор баталсугай.
2. Үндэсний хорооны ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Үндэсний хороо (Л.Оюун-Эрдэнэ)-нд, зайлшгүй шаардлагатай асуудлаар Ажлын дэд хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулж ажиллуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид тус тус даалгасугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид даалгасугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
Эрхлэх газрын дарга

Ц.НЯМДОРЖ



**ОЛИМПИЗМЫГ ДЭЛГЭРҮҮЛЭХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ  
ХАНГАХ, АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ  
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: -Монгол Улсын Ерөнхий сайд;
- Орлогч дарга: -Боловсрол, шинжлэх ухааны сайд
- Гишүүд: -Батлан хамгаалахын сайд;  
-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд;  
-Барилга, хот байгуулалтын сайд;  
-Соёлын сайд;  
-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд;  
-Эрчим хүчний сайд;  
-Эрүүл мэндийн сайд;  
-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;  
-Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;  
-Биеийн тамир, спортын улсын хорооны дарга;  
-Үндэсний хөгжлийн газрын дарга;  
-Ерөнхий сайдын Ажлын албаны Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга;  
-Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимиын ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр).
- Нарийн бичгийн дарга: -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга.